



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 30,590,000.00 (гучин сая таван зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэ, 16,331,428.19 (арван зургаан сая гурван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун хорин найман төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Дорноговь-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Гансүх, “Дорноговь-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 30
тогтоолын хавсралт

“Ингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГ-аас “Дорноговь-А33А” ТӨХК-ийн балансад шилжүүлэх
хөрөнгийн жагсаалт

Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтанд орсон огноо	Хэм жих нэгж	Тоо ширхэг	Нийт гүйлт /км/	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл (төгрөгөөр)
маркийн, УБ 50-30 дугаартай, Арлын -TJАНFVHR26154, лгүүрийн дугаар - B0458814	2005/2011	ш	1	1565	30,590,000.00	16,331,428.19	14,258,571.81
			1		30,590,000.00	16,331,428.19	14,258,571.81
ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)		30,590,000.00 (гучин сая таван зуун ерэн мянган)	16,331,428.19 (арван зургаан сая гурван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун хорин найман төгрөг арван есөн мөнгө)	14,258,571.81 (арван сая хоёр зуун таван мянга таван зуун нэгэн төгрөг арван мөнгө)